



Монгол Улс

**ОУВС-гийн Дүрмийн 4 дүгээр заалтын дагуу хийгдсэн 2011 оны зөвлөлдөх
хэлэлцүүлгийн ажлын хэсгийн урьдчилсан дүгнэлт**

2011 оны 2 дугаар сар

Дүрмийн 4 дүгээр заалтын 2011 оны зөвлөлдөх хэлэлцүүлэг Монгол Улсын эдийн засгийн сэргэлт хүчтэй явагдахын зэрэгцээ хэт халалтын шинж тэмдэг илэрч байгаа үед явагдлаа. Инфляци хэдийнээ хэт өндөр түвшинд хүрч, төсвийн зарлага их хэмжээгээр нэмэгдэж байгаа нь нөхцөл байдлыг улам доройтуулах болно. Хэлэлцүүлгийн гол сэдэв нь бизнесийн өнөөгийн мөчлөгийг зөв залах, мөн түүнчлэн Монгол Улсын асар их эрдэс баялгийн нөөцийг урт удаан хугацаанд үр өгөөж өгөх хөгжил цэцэглэлт болгох нөхцлийг хангах бодлогын хүрээнд төвлөрлөө.

- 1. Сүүлийн үед гарсан өөрчлөлт хөгжил.** Эдийн засгийн өсөлт өнгөрсөн онд эрс сайжирч, 6.1 хувьд хүрсэн. Зуд турханы улмаас хөдөө аж ахуй, ялангуяа мал аж ахуйн үйлдвэрлэл огцом багассан хэдий ч ийм хэмжээний сэргэлт гарсан нь үнэхээр гайхалтай. Гэвч хүнсний барааны нийлүүлэлтэнд үүссэн цочролын улмаас 2010 оны ихэнх хугацаанд инфляци хоёр оронтой тоогоор илэрхийлэгдсэн бөгөөд үүнд махны үнэ өссөн нь голлох үүрэг гүйцэтгэлээ. Зэсийн үнэ нэмэгдэж, нүүрсний үйлдвэрлэл хурдацтай өссөн нь экспортын өндөр өсөлтийг бий болгож, гадаад валютын нөөцийг түүхэнд байгаагүй өндөр түвшинд хүргэхэд нөлөөлөв.
- 2. Цаашдын төлөв.** Эдийн засгийн өсөлт 2011 онд өндөр хэвээр байж, 10 орчим хувь хүрч нэмэгдэхээр байна. Харин улсын нэгдсэн төсвийн зарлагыг их хэмжээгээр өсгөж, төлөвлөгөө ёсоор хэрэгжүүлэх гэж байгаа нь зах зээл дээр илүүдэл эрэлтийг бий болгож, улмаар инфляцийг хөөрөгдөн, импортыг нэмэгдүүлэх шалтгаан болж байна. Инфляцийн түвшин 2011 оны эцэст 20 орчим хувьд хүрч болзошгүй байна. Дунд хугацаанд уул уурхайн үйлдвэрлэл нэмэгдэж, эдийн засгийн өсөлтийг түрэх бөгөөд 2013 оны үед Оюу толгойн уурхайн олборлолт эхлэхэд өсөлт илүү өндөр түвшинд хүрэх болно.
- 3. 2011 оны нэгдсэн төсөв.** Монголчуудын гуравны нэг ядуурлын түвшингээс доогуур амьжиргаатай, эдийн засгийн хямрал, өнгөрсөн жилийн зудын үр нөлөө бүрэн арилаагүй байгаа үед Засгийн газрын зүгээс хүн амын амьжиргаанд шуурхай дэмжлэг үзүүлэх хүсэл санаа агуулж байгаа нь ойлгомжтой. Гэвч нэгдсэн төсвийн зарлагыг энэ онд асар ихээр нэмэгдүүлсэн нь эдийн засгийн ашиг тусаас илүү хор хохирол дагуулах болно. Төр засгаас олгож байгаа тусламж дэмжлэгийн үр өгөөж өсөн нэмэгдэж байгаа инфляцид залгигдаж, хувийн хэвшил шахагдан, төгрөгийн бодит ханшны чангаралт эрчимжинэ. Тэгэхлээр эцсийн дүндээ өрхийн худалдан авах чадвар доройтож, импортын бараа бүтээгдэхүүн дотоодод үйлдвэрлэсэн бараатай харьцуулахад хямдран, импорт өсч, дотоодын бизнесийн өрсөлдөх чадвар буурснаар хөрөнгө оруулалт, ажил эрхлэлтэнд сөргөөр нөлөөлөх болно. Инфляци ийнхүү өндөр түвшинд хүрэх, нэн ялангуяа хүнсний гол бүтээгдэхүүнүүд дээр төвлөрөх нь ядууст гойд хүнд тусдаг болохыг олон улсын туршлага харуулж байна. Учир нь ядуусын хэрэглээнд

хүнсний бүтээгдэхүүнүүд өндөр хувь эзэлдэг бөгөөд үнийн хөөрөгдөл тэдний бодит орлогыг бууруулж байдгийн эсрэг хамгаалах арга хэрэгсэл тэдэнд бага байдаг. Иймд, 2011 оны нэгдсэн төсөвт тодотгол хийж, зарлагыг үлэмж хэмжээгээр танах шаардлагатай байна.

4. **Дунд хугацааны төсвийн хүрээ.** Монгол Улсын эрдэс баялаг нийт монголчуудад урт удаан хугацааны хөгжил цэцэглэлт авчирах нөхцлийг бүрдүүлэхийн тулд төсвийн ухаалаг бодлого хэрэгтэй. Энэ нь бодит амьдрал дээр төсвийн зарлагын өсөлтийг тодорхойлохдоо дараах зорилтыг хангана гэсэн үг юм. Үүнд: (1) эдийн засгийн өсөлтийг жигд хэмтэй болгоход дэмжлэг болох (төсвийн мөчлөг сөрсөн бодлогоор дамжуулан); (2) хувийн хэвшил өсөн хөгжих орон зай үлдээх; (3) улсын төсөв, эдийн засгийг бараа, түүхий эдийн дэлхийн зах зээлийн үнийн уналтаас хамгаалах хэрэгслэлтэй байх. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг өнгөрсөн онд батлан гаргасан нь энэ чиглэлээр гаргасан чухал ач холбогдолтой ололт юм. Гэтэл 2011 оны төсөв нь энэхүү амжилтаас том алхам ухарсан явдал боллоо. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг үг үсэггүй, үзэл баримтлалыг чанд даган мөрдсөнөөр чухамхүү үр дүнд хүрэх бөгөөд ингэж эс чадаваас хуулийн найдвартай байдал алдагдаж, бодлогын алдааны улмаас Монгол Улсад урьд өмнө нь үүсч байсан тэлэлт-агшилтын мөчлөг дахин давтагдахаас сэргийлэх боломжгүй болно. Үүний тулд ойрын жилүүдэд төсвийн зарлагыг нэмэгдүүлэхгүй байх, тухайлбал зарлагын бодит өсөлтийг царцааж, 2013 оноос хүчин төгөлдөр мөрдөгдөх ёстой төсвийн хүрээний тоон үзүүлэлтийг хангаханд бэлтгэх ёстой. Түүнээс гадна, төсвийн гадуурх арга хэрэгсэл эсвэл засгийн газрын баталгааг ашиглах замаар хуулийн зохицуулалтыг тойрч гарах оролдлого хийхгүй байх нь мөн чухал байна. Эдгээр нь хуулийг дагаж мөрдсөнөөс гарах учиртай эдийн засгийн үр өгөөжийг үгүй хийж, төсвийн эрсдэлийг нэмэгдүүлэн, ил тод байдлыг алдагдуулах зэргээр нэмэлт хор хохирол учруулах болно. Хөгжлийн банк, төр хувийн хэвшлийн түншлэл, улсын баталгаа зэрэг нь төсвийн хүрээний эрсдэлийн учир шалтгаан болох бөгөөд эдгээрийг бодит ажил болгохоор бол оновчтой удирдан зохицуулж, олон улсын сайн туршлагыг дагах хэрэгтэй.

5. **Төсвийн хүрээний бүтцийн шинэчлэл.** Төсвийн хүрээнд тодорхой чиглэлээр бүтцийн шинэчлэл хийх гэж байгаа нь сайшаалтай бөгөөд тэдгээрийг хэрэгжүүлэх нь зүйтэй. Нийгмийн халамжийн шинэчлэлийн хүрээнд хэрэгцээт бүлэгт чиглэсэн ядуурлын тэтгэмжийг нэвтрүүлэх нь хамгийн чухал тэргүүлэх чиглэл бөгөөд Монгол Улсын хамгийн эмзэг бүлгийн хүмүүст ашиг тусаа өгч, төсвийн уян хатан байдлыг нэмэгдүүлнэ. Засгийн газрын төлөвлөгөө ёсоор Төсвийн нэгдсэн хуулийг батлан гаргаснаар засаглал хоорондын төсвийн харилцааг шинэлэг түвшинд гаргаж, төсвийн гүйцэтгэлийг сайжруулан, төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, дунд хугацааны төсвийн бодлогыг тодорхойлох ажлыг боловсронгуй болгоход чухал үүрэг гүйцэтгэх боломжтой. Том татвар төлөгчийн албаны чадавхийг бэхжүүлэх ажлыг үргэлжүүлэн хийж, татвар төлөгчдөд үзүүлэх үйлчилгээг сайжруулан, татварын орлого хураалтыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ үр ашигтай явуулах нөхцөл бүрдэх болно. Үүний эсрэгээр, татварын хөнгөлөлт чөлөөлөлтийг нэмэх, зарим чухал салбаруудыг дэмжихэд НӨАТ-ыг ашиглах нь ихээхэн үр ашиг муутай байхаас гадна үр дүнгүй байх болно. Түүгээр зогсохгүй татварын удирдлагыг хүндрүүлэх, орлого алдагдах эрсдэл агуулах зэргээр хор хохирлыг нэмэгдүүлнэ.

6. **Мөнгөний бодлого.** Инфляци аль хэдийнээ маш өндөр түвшинд хүрч, томоохон тэлэлт агуулсан нэгдсэн төсөв инфляцийг улам бүр хөөрөгдөх болно. Энэ оны нэгдсэн төсвийн зарлагыг танахгүй бол мөнгөний бодлогын хүрэх үр дүн хязгаарлагдмал байх болно. Гэсэн хэдий ч төв банк инфляцийн эсрэг илүү урьтаж арга хэмжээ авч, хүүг шууд өсгөх замаар мөнгөний бодлогыг хатууруулах орчилын суурийг нэн даруй тавих нь зүйтэй. Төв банкны бодлогын хүү бодит үзүүлэлтээрээ аль хэдийнээ сөрөг утгатай болсон бөгөөд инфляци нэмэгдэхийн хирээр сөрөг утгын дүн улам бүр ихэснэ. Инфляцийн хөөрөгдлийг тогтоон барихад хүүгийн түвшин өндөр байх нь чухал ач холбогдолтой. Мөнгөний бодлогыг хатууруулснаар хувийн хэвшилд очих зээлийн хэмжээ багасч, хувийн хэвшлийн үйл ажиллагааны эрчмийг удаашруулах нь гарцаагүй. Хувийн хэвшил ийнхүү шахагдах нь хүсүүштэй зүйл биш боловч инфляцийг улам бүр хөөрөгдүүлэхээс дээр хувилбар юм. Гэхдээ хувийн хэвшлийг ийнхүү шахсан явдлын хариуцлага нь төсвийн задгай бодлого хэрэгжүүлэхээр гаргасан шийдвэртэй шууд холбоотой бөгөөд мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага одоо эрх мэдэлд байгаа арга хэрэгслээрээ үр дагаврыг нь залруулах хэрэгтэй болж байна. Төв банкны мөнгөний бодлогын үндсэн зорилго нь инфляци гэдгийг илүү тодорхой зааж өгснөөр инфляцийн эсрэг авч буй энэхүү арга хэмжээнд тус нэмэр болох болно.

7. **Макро эдийн засгийн бодлогын хослол.** Төсвийн тэлэх бодлогыг мөнгөний хатуу бодлоготой хослуулах шаардлага нь одоогийн нөхцөлд үр ашигтай бодлогын хослол болж чадахгүй, харин ч макро эдийн засагт тогтворгүй байдлыг үүсгэж, инфляцийн хөөрөгдөлд хүргэнэ. Инфляцийн хөөрөгдөл нь нийгмийн хэмжээнд томоохон хор хохирол авчирч, үнийн өсөлт ядуу өрхүүдийн худалдан авах чадварыг эрс багасгадаг учраас тэдэнд илүү хүндээр тусдаг. Мөн түүнчлэн инфляци өссөнөөр хадгалуулсан мөнгөний үнэ цэнэ буурч, өндөр настнууд гэх мэт тогтмол орлоготой хүмүүст дарамт учруулдаг. Макро эдийн засгийн илүү оновчтой бодлого хэрэгжүүлэхийн тулд энэ оны нэгдсэн төсвийн зарлагыг нилээд их хэмжээгээр танаснаар мөнгөний бодлогыг хатууруулах шаардлагатай хэмжээг багасгаж болно. Ингэснээр 2011, 2012 онд инфляцийг доогуур барьж, эдийн засгийн өсөлт аядуу болж, хүүгийн түвшин буурч, төгрөгийн бодит ханшийн чангаралт багасах боломжтой болно. Дотоодын эдийн засгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, хувийн хэвшлийн үйл ажиллагааны орчинг сайжруулахад эдгээр нь хэрэгтэй байна.

8. **Ханшийн бодлого.** Уян хатан ханшийн тогтолцоо өнгөрсөн нэг жил хагасын хугацаанд үр дүн сайтай байлаа. Гадаад валютын нөөц түүхэндээ байгаагүй өндөр түвшинд хүрч, төгрөгийн нэрлэсэн ханш зах зээлийн эрэлт нийлүүлэлтээр тодорхойлогдож ирлээ. Гадаад валютын их хэмжээний бөөн урсгалаас үүдэлтэй төгрөгийн ханшийн илүүдэл савалгааг төв банк дарж чадсан бөгөөд интервенцийн энэхүү стратегийг цаашид үргэлжлүүлэн мөрдөх нь зохистой хэвээр байна. Өнгөрсөн онд төгрөгийн нэрлэсэн ханш чангарснаар зах зээл дээрх эх үүсвэрийн хэмжээг багасгахад нөлөөлж, инфляцийн өсөлтийг бууруулсан. Цаашдын байдлыг харахад Монгол Улсын эдийн засагт уян хатан ханшийн тогтолцоо нэн тохиромжтой хэвээр байх болно. Тодруулбал, ханш уян хатан байснаар инфляцийг хяналтандаа байлгах боломжтой болж, гадаад цочролын үр нөлөөг шингээж, уул уурхайн салбарын хурдацтай өсөлтөөс дунд хугацаанд гарцаагүй үүсэх бодит ханшийн чангаралтад түлхэц болно.

9. **Банкны систем.** Хувийн хэвшлийн хөгжлийг дэмжихэд банкны эрүүл систем чухал байдаг. Банкны систем бат бөх байна гэдэг нь бизнес эрхлэгчид, малчид, аж ахуйн нэгжүүд зээлийг боломжийн нөхцөлөөр авах боломжийг бүрдүүлэхийн зэрэгцээ хадгаламж эзэмшигчдийн хөрөнгийг үр дүнтэй хяналт шалгалт, зохицуулалтаар дамжуулан хамгаалахад оршино. Үүнтэй уялдуулаад банкны хяналт шалгалтыг бэхжүүлэх чиглэлээр сүүлийн үед хийсэн ажлууд сайшаалтай алхам болсныг дурьдах хэрэгтэй. Харин одоо хүчин төгөлдөр байгаа журам зааврыг хатуу мөрдүүлж, хууль дүрмийг хангаж ажиллахгүй байгаа аливаа банкинд дээр шийдвэртэй арга хэмжээ авах замаар хяналт шалгалтын тогтолцооны хүлцэнгүй байдлыг халах цаг болоод байна. Үүний зэрэгцээ Банкны салбарыг чадавхижуулж, өөрийн хөрөнгөөр дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хууль дүрмийн хэрэгжилтийг бүрэн дүүрэн хангуулахын тулд цаг хугацаа шаардлагатай байгаа банкинд санхүүгийн түр дэмжлэг үзүүлэх ил тод бөгөөд шударга механизмтай болох боломжтой. Энэ хуулийн баримт бичгийг шуурхай баталж гаргах нь хамгийн чухал ажил байх учиртай. Түүнээс гадна, банкны бүтцийн өөрчлөлттэй холбоотойгоор гарсан болон цаашид гарах зардлыг төв банк бус улсын төсвөөс цаг алдалгүй хариуцаж байх нь зүйтэй.

10. **Дунд хугацааны төлөв.** Уул уурхайн салбарыг эдийн засгийн эргэлтэнд оруулснаар эдийн засгийн өсөлт өндөр болж, нийт монголчуудад хөгжил цэцэглэлт авчиргах боломж бүрдэн Монгол Улсыг эдийн засгийн гэрэлт ирээдүй хүлээж байна. Гэхдээ хөгжил цэцэглэлт ирэх нь баталгаатай биш юм. Дэлхийн олон улс орнууд “баялгийн хараалд” өртөж, эрсдэл байдгийг бодитойгоор харуулсныг санах хэрэгтэй. Монгол Улсад саяхан нүүрлэсэн хямрал ч бас амжилтанд хүрч чадахгүй байхын хор хохирол ямар байдгийг тод харуулсан. Амжилтанд хүрэхийн тулд макро эдийн засгийн бодлого сахилга баттай байх ёстой. Үүнд: (1) төсвийн зарлагыг өсгөх дарамтыг бууруулж, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг хатуу чанд мөрдөх; (2) мөнгөний бодлогыг инфляцийг хазаарлахад чиглүүлэх, түүний дотор үнийн хөөрөгдөлийг сөрж цаг алдалгүй хүүгийн түвшинг өөрчлөх; (3) уян хатан ханшийн тогтолцоог үргэлжүүлэх; (4) зохистой харьцааны журам заавар, хяналт шалгалтыг хэрэгжүүлэх замаар банкны системийг хамгаалах. Эдгээр бодлогыг хослуулан хэрэгжүүлснээр Монгол Улсын эрдэс баялгаас эдийн засгийн өндөр, тогтвортой, тэгш өсөлтийг бий болгох нөхцөл бүрдэх болно.

* * *

Монгол Улсын эрх бүхий байгууллагууд ажлын хэсгийг найрсаг дотноор хүлээн авч, яриа хэлэлцүүлгийг илэн далангүй өрнүүлсэнд чин сэтгэлээсээ талархснаа энэ дашрамд илэрхийлье.